

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	3.
Санхүүгийн тайлангийн тодруулга	..
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	5
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	5
4. Аудитын тайлан.....	5
4.1 Ерөнхий зүйл.....	7
4.2 Дотоод хяналт.....	7
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
4.4 Материаллаг байдал	8
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	8
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
8. Аудитын илрүүлэлт	9
8.1 Залруулсан алдаа	9
8.2 Төлбөрийн акт.....	10
8.3 Албан шаардлага	10
8.4 Зөвлөмж	10
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт


**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.03.15 № 252
танай _____ ны № _____ т

ТЭШИГ-УС ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ П.ОЮУНБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Тэшиг-Ус" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:/bichighereg/2022A4toot

006020319

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**3. Санхүүгийн тайлангийн тодруулга****3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Тэшиг-Ус ОНӨААТҮГ-ын зорилго нь “Хэрэглэгчдийг найдвартай Дулаан, Цэвэр усаар хангаж эрүүл ая тухай нөхцөлийг бүрдүүлэх орчин үеийн шинэ дэвшилтэд техник технологи нэвтрүүлж орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж найдвартай тулаанаар хангагч байгууллага болоход оршино.” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг сумын төрийн байгууллага болон ААН, айл өрхийн хэрэглэгчдийг стандартад нийцсэн дулаан, цэвэр усаар тасралтгүй хангаж бохир усыг цэвэрлэж байгальд нийлүүлэх үүрэг бүхий, орон нутгийн өмчийг гэрээгээр ашиглах, өөрийн балансад бүртгэлтэй эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай, өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тэшиг сумын ИТХ-ын 2014 оны 29 дүгээр тогтоолоор “Тэшиг Ус” ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д “орон нутгийн өмчийн талаар:”, ж/орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах; гэсэн заалттай нийцсэн байна.

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 60 дугаар тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 2021 онд цалин, урамшуулал олгоогүй, үйл ажиллагааны зардалд 100.0 мянган төгрөг олгосон байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тэшиг-Ус ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	713.38	20805.87	20092.49
БХХО	0.00	0.00	0.00
Авлага	6311.59	7608.50	1296.91
Урьдчилгаа	0.00	0.00	0.00

Бараа материал	48502.73	13427.94	-35074.79
Үндсэн хөрөнгө	26687.26	18167.10	-8520.16
Биет бус хөрөнгө	162.44	0.00	-162.44
Нийт хөрөнгийн дүн	82377.40	60009.41	-22368.00
Өр төлбөрийн дүн	117204.61	44273.02	-72931.59
Богино хугацаат өглөг	117204.61	44273.02	-72931.59
Урт хугацаат өглөг	0.00	0.00	0.00
Эздийн өмч	-34827.21	15736.38	50563.59
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	82377.40	60009.41	-22368.00

Мөнгөний үлдэгдэл 20805.8 мянган төгрөгийн 20789.0 мянган төгрөг нь арилжааны банканд, 16.8 мянган төгрөг нь кассанд дахь үлдэгдэл байна.

Авлага оны эхэнд 6311.6 мянган төгрөг оны эцэст 7608.5 мянган төгрөг болж өмнөх оноос 1296.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу цэвэр усны төлбөрийг төрөөс төлөх болсонтой холбоотой 1870.5 мянган төгрөгийн төрөөс олгох усны төлбөрийн дутууг авлага тусгасан байна.

Авлагын үлдэгдлийг авч үзвэл НДШ-ийн 38.5, байгууллагаас авах 5120.9 мянган төгрөгийн авлагын 2744.8 нь өмнөх оны авлагуудыг барагдуулаагүй хөдөлгөөн өөрчлөлт ороогүй авлагууд байна. Хүмүүсээс авах авлагын 2449.1 мянган төгрөгийн авлага нь 2017 онд үүссэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхэнд 48502.7, оны эцэст 13427.9 мянган төгрөг болж 35074.8 мянган төгрөгөөр буурсан нь нүүрсний үлдэгдэл буурсантай нь холбоотой байна.

Тайлант онд худалдан авалтаар 60980.1 мянган сая төгрөг, үнэ төлбөргүй болон шилжүүлэн авч нэмэгдсэн хөрөнгө байхгүй, зарцуулсан 96058.9, акталсан 915.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж 13.4 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 71125.4 сая, эцсийн үлдэгдэл 73465.2 мянган төгрөг болж өмнөх оноос 2339.8 мянган төгрөгөөр өссөн нь Тэшиг-Ус ОНӨААТҮГ-ын ТЗУ-ын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хөрөнгө зарцуулах тухай 08 дугаар тогтоол гарч санхүүд ашиглах компьютер авч, программ хангамжийн 300.0 мянган төгрөгийг данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд 11159.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2639.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн байна. ийн 177.1 сая төгрөг нь барилга орлогод авахад дутуу үнийн дүнгээр орлогодсоныг тайлант онд нэмж авсан, тушаалаар 8.6 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 117204.6, эцсийн үлдэгдэл 44123.2 мянган төгрөг болж өмнөх оноос 73081.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өглөгийн дансны үлэгдлийг авч үзвэл хувь хүмүүс өгөх өглөгийн 28621.9 мянган төгрөгийн өглөгийн 81.4 хувь буюу 23313.6 мянган төгрөг нь нүүрс тээврийн өглөг, татварын 15280.3 мянган төгрөгийн өглөгийн 8818.2 НӨАТ, 138.2 ХХАОТ-ын, 6323.8 мянган төгрөг нь ААНБОАТ байна.

Тайлант үеийн үр дүн: 2018 оноос хойш санхүүгийн тайланд татварын байгууллагад НӨАТ, ХХОАТ, ААНОТ зэрэг өрийг татварын байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн программын зөрүү 7374.5 мянган төгрөгийг хуримтлагдсан ашиг дансанд хаасан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТУЗ-н 2020 оны 02 тогтоолоор “ТЭШИГ-УС” ОНӨААТҮГ-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 381,422.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 374,190.0 мянган төгрөгөөр, 7.2 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд төсөв төлөвлөсөн байна. ТУЗ-ийн 2021 оны 08 тогтоолоор 2600.0 мянган төгрөгөөр тодотгосон албан хэрэгцээнд Айсэр нөтбүүк худалдан авсан байна.

Нийт орлогыг 381,422.1 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 373,448.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 7973.3 мянган төгрөг буюу 2.1 хувиар тасарсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг Ковидын үед ажиллаагүй тул цэвэр бохир усны хэрэглээ буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлыг 374,190.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 295,989.0 мянган төгрөг буюу 79.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь төлөвлөсөн орлого буурсан мөн тэвчиж болох зардлыг танасан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 43189.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 35957 сая төгрөгөөр илүү байгаа нь тэвчиж болох зардлыг танасан мөн өр төлбөр буурсан нөлөөлж байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг-Ус ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад анхан шатын баримтын бүрдэл хангах, авлага өглөгийг барагдуулах, санхүүгийн программд шинэчлэл хийх, байгууллагын дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн ч анхан шатны баримтын бүрдэл анхаарах зүйл байна. Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, чанар хүртээмж, өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж биелэлтийг тооцсон ч ЗГ-ын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" байгууллагын дотоод хяналт шалгалт хийх журмын дагуу

төлөвлөгөөнд тусгасан ажил бүрээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаагүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ч 2018 хойш шинээр баталсан хууль тогтоомж, санхүүгийн бүртгэлтэй тохируулан баяжилт хийгдээгүй байна.

Дотоод аудитын бүтэц орон тоо батлагдаагүй бөгөөд дээд шатны дотоод хяналт болох санхүүгийн хяналт, аудитын алба хяналт шалгалтыг хийж байна. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Тэшиг-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 275,525.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5510.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4408.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээлэл хугацаа хоцроосон, "Санхүүгийн тайлан хагас, бүтэн жил, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа

жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор," гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

И-баримтаас түүвэр хийхэд 8 гүйлгээний 1397800 төгрөгийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудитаар хийгдээгүй, өмнөх аудитаар нийт 117687.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 116840.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 846.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	6	846.5	6	846.5			
Нийт дүн							

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын программ байхгүй, бараа материалын орлого, зарлагыг тусад нь бүртгэж байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5077.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 689.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2990.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1397.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3680.1 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 4408.4 мянган төгрөгийн түвшинээс 728.3 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа зөрчил байхгүй.

8.2 Төлбөрийн акт

- Харилцах данс болон бэлэн мөнгөний гүйлгээг шалгахад ТЗУ-ийн даргын үйл ажиллагаанд 100000 төгрөгийн олгосон анхан шатны баримтгүй зарцуулсан, харилцагч Э.Ууганбаяртай холбоотой өмнөх оны хүнсний өглөгийг төлөхдөө тооцоо нийлсэн актаас 280000 төгрөгөөр илүү шилжүүлсэн, мөн тайлант онд 500000 төгрөгийн хүнсний ногоо нийлүүлэхээс 186000 төгрөгийн хүнсний ногоо орлогод авч 123600 төгрөгөөр тооцоо нийлж авлага үүсгэж 190400 төгрөгийн материал орлогод аваагүй, нийлүүлээгүй байна. НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Хувь хүнээс худалдан авсан 1194800 төгрөгийн бараа материалын үнээс ХХОАТ-ын 10 хувь суутгаагүй 119480 төгрөг байгаа нь ХХОАТ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 25.4-т "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулсан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсвэл хувь хүний орлого татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

8.3 Албан шаардлага

- Өмнөх онуудын шийдвэрлэгдээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 2449153 төгрөгийн авлага, 541000 төгрөгийн өглөг байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх." гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээлэл хугацаа хоцроосон, "Санхүүгийн тайлан хагас, бүтэн жил, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: И-баримтаас түүвэр хийхэд 8 гүйлгээний 1397800 төгрөгийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, тухайд бүр нь цахим И-баримтыг хангуулан бүртгэлд тусгаж байх.

2. НБББББ холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын НБББББ-ийг 2018 онд захирлын тушаалаар баталж үүнээс хойш шинээр баталсан хууль тогтоомж, санхүүгийн бүртгэлтэй тохируулан баяжилт хийгдээгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ийг шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцүүлэн баяжилт хийх.

3. Авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2021 оны санхүүгийн тайланд 44273021 төгрөгийн өр байгаагийн 34.5 хувийг татварын өр эзэлж байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын болон бусад өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авах

4. Санхүүгийн тайлангийн программ хангамжтай холбоотой асуудал

Санхүүгийн "Smart balance" программыг ашиглаж байгаа боловч, шинэчлэлт сайжруулалт хийгээгүй, санхүүгийн болон бараа материалын программ байхгүй, бараа материалын орлого, зарлагыг тусад нь бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программын шинэчлэлт хийж, бараа материал болон кассын тайлан зэргийг нэгтгэж гаргадаг болгох, НБББББ-ыг санхүүгийн программын шинэчлэлтэй уялдуулж шинэчилж, ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.-т "үнэн зөв байх;" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, чанар хүртээмж, өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж биелэлтийг тооцсон ч ЗГ-ын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" байгууллагын дотоод хяналт шалгалт хийх журмын дагуу төлөвлөгөөнд тусгасан ажил бүрээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, төлөвлөгөөнд туссан ажил бүрээр удирдамж төлөвлөгөө боловсруулан ажиллаж, гарсан алдаа зөрчлийн биелэлтийг тооцдог байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

